

17 Байршлууд бичигдсэн

17.1 Бетлехемд төрсөн

²Харин Бетлехем Ефрата аа, хэдийгээр чи Иудагийн бүлүүдийн дунд өчүүхэн авч, Миний төлөө Израилийг захирах Нэгэн нь чамаас төрөн гарах болно.

Энэ нь эртнээс хийгээд мөнхөөс үүдэлтэй”. (Мика 5:2 АБ 2004)

17.2 Египет рүү аваачсан

¹Израилийг залуу байх үед Би түүнийг хайрлан, Өөрийн хүүг Египетээс дуудан гаргасан. (Хосеа 11:1 АБ 2004)

¹⁴Иосеф босоод шөнөөр Хүүг эхтэй нь авч Египетийг зорин хөдөллөө. ¹⁵Тэгээд Херодыг нас бартал тэндээ байв. Эзэн эш үзүүлэгчээрээ дамжуулан “Би Хүүгээ Египетээс дуудан гаргав” гэсэн нь ийнхүү биелжээ. (Матай 2:14-15 АБ 2004)

17.3 Галил

Галил дахь үйлчлэл

¹Зовлонтой байсан газар нутагт дахин харанхуй болохгүй. Урьдын цагт Тэр Зебулун болон Нафталийн нутагт жигшүүрээр хандаж байсан бол дараа нь харь үндэстнүүдийн Галил, Иорданы нөгөө талд, тэнгисийн хажуугаар сүр жавхлантай болгоно. ²Харанхуйд алхаж яваа хүмүүс агуу их гэрлийг үзнэ. Харанхуй газарт амьдарч байгаа хүмүүс дээр гэрэл тусна. (Исаиа 9:1-2 АБ 2004)

¹²Есүс Иоханыг баривчлагдсаныг сонсоод, Галил уруу буцлаа. ¹³Тэр Назарыг орхиж, Зебулун болоод Нафталийн мужийн нуурын эрэг дэх Капернаумд ирж суурьшив. ¹⁴Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар хэлүүлсэн нь биелэгдсэн бөгөөд “Иорданы чанад тэнгис хүрэх зам дээрх Зебулуны болоод Нафталийн нутаг, харь үндэстнүүдийн Галил, ¹⁶харанхуйд

суугч хүмүүс агуу их гэрлийг харж, үхлийн нутагт ба сүүдэрт суугчдын дээр гэрэл тусав” (Матай 4:12-16 АБ 2004)

⁴⁵Тэгээд харуулуудыг ахлах тахилч нар болон фарисайчууд дээр ирэхэд, тэднээс -Та нар Түүнийг юунд авч ирсэнгүй вэ? гэсэнд ⁴⁶харуулууд -Энэ хүний ярьж байгаа шиг ярьсан хүн ер үгүй билээ гэжээ. ⁴⁷Тэгтэл фарисайчууд тэдэнд -Та нар бас төөрчихөв үү? ⁴⁸Захирагчид болон фарисайчуудаас хэн ч Түүнд итгээгүй биз дээ? ⁴⁹Харин Хуулийг мэддэггүй энэ ард олон л хараагджээ гэлээ. ⁵⁰Тэдний нэг болох урьд нь Есүс уруу ирсэн Никодем тэдэнд ⁵¹-Бидний Хууль хүний юу хийж байгааг нь эхлээд тэр хүнээс сонсоогүй, мэдээгүй байж шүүдэг бил үү? гэв. ⁵²Тэд түүнд -Та бас Галилынх уу? Нягтлан үз, Галилаас ямар ч эш үзүүлэгч гарахгүй гэж хэлэв. ⁵³Хүмүүс гэр гэр уруугаа явлаа. (Иохан 7:45-53 АБ 2004)

[] Галилей агуу гэрлийг харна гэж эш үзүүлсэн. Та та тэр гайхалтай гэрлийг харсан уу?

[] Та Галилын тухай бичсэн эш үзүүлэлийг мэдэх үү?

17.4 Рама

¹⁵ЭЗЭН ингэж айлдаж байна.“Ихэд гашуудан уйлах дуу Рамад сонсдов. Рахел хүүхдүүдийнхээ төлөө уйлна.Тэд байсангүй учир тэрээр тайтгарлыг авахгүй байна”. (Иеримиа 31:25 АБ 2004)

Херод нялх хүүхдүүдийг хөнөөсөн нь

¹⁶Херод зурхайчдад мэхлэгдсэнээ мэдээд ихэд хилэгнэн, тэднээс тодруулж авсан цагийн дагуу хүн явуулаад, Бетлехем болон түүний ойр орчимд хоёр болоод түүнээс доош насны эр хүйстэй бүх хүүхдийг хөнөөлгөв. ¹⁷Эш үзүүлэгч Иеремиагаар дамжуулан хэлсэн нь тэр цагт биелэгдсэн агаад ингэхдээ ¹⁸“Ихэд гашуудан уйлах дуу Рамад сонсдов. Рахел тайтгарлыг авахаас татгалзан, Хүүхдүүдийнхээ төлөө уйлна. Учир нь тэд нар нь байсангүй (Матай 2:16-18 АБ 2004)

[] Та шүүлтийн газар байна уу?

17.5 Назар

¹⁹Харин Херодыг нас барсны дараа Египетэд Эзэний тэнгэр элч Иосефт зүүдэнд нь үзэгдэж, ²⁰-Бос, Хүүг эхийнх нь хамт авч, Израиль нутагт оч. Хүүхдийн амийг хайгчид үхсэн гэв. ²¹Тэр босож Хүүг эхтэй нь авч, Израиль нутагт ирэв. ²²Харин Архел эцэг Херодынхоо оронд Иудейг хаанчилж байгааг тэр сонсоод тийш очихоос айжээ. Бурхан зүүдэнд нь сэрэмжлүүлснээр, тэр Галилын нутаг уруу явав. ²³Тэгээд Назар гэгдэх хотод очиж суурьшив. “Назарынх гэж Түүнийг дуудах болно” гэж эш үзүүлэгчдээр айлдуулсан нь ийнхүү биелэгджээ. байсангүй (Матай 2:19-23 АБ 2004)

[] Та эргэн тойрныхоо хүмүүст ад үзэгддэг хүмүүсийг хүндэлдэг үү?

17.6 Иерусалим

²Би Иерусалимын эсрэг тулалдуулахаар бүх үндэстнүүдийг цуглуулна. Хот эзлэгдэж, гэр орнуудыг тонон, эмэгтэйчүүдийг хүчирхийлэн, хотын хагас нь цөлөгдөх боловч ард түмний бусад нь хотоос таслагдахгүй. (Зехариа 14:2 АБ 2004)

[] Та Иерусалимын төлөө залбирах ёстой юу?